

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/292

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.ХОРОЛСҮРЭН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Сайншанд сумын ИТХ Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

Аудитын тайлан

2.1. Оршил

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сайншанд сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Хоролсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 12-ноос 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дүгээр сарын 04-ний өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сайншанд сумын ИТХ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлж, хөгжүүлэх гэсэн эрхэм зорилго дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Сайншанд сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Аймгийн ИТХ-ын тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайншанд сумын ИТХ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Сайншанд сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сайншанд сумын ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 118,802.9 мянган төгрөгөөс тооцон 1,118.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,118.0 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын 1 хувиас давсан алдааг материаллаг алдаа гэж үзсэнтэй холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.3 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	3,148.4	3,308.8	-49.6
Үндсэн хөрөнгө	8,022.0	8,070.4	48.4
Нийт хөрөнгө	11,380.5	11,379.2	-1.3
Өр төлбөр	0.0	657.0	657.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,768.3	10,722.2	-1,046.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,380.5	11,379.2	-1.3

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 17,594.2 мянган төгрөгийн материал бэлтгэж 17,433.8 мянган төгрөгийн зарцуулалт гарсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь өөрийн хөрөнгөөр бусад үндсэн хөрөнгө дансанд 4,000.0 мянган төгрөгийн сүүдрэвч, машин тоног төхөөрөмжийн дансанд 417.9 мянган төгрөгийн принтер худалдан авч, 4,369.5 мянган төгрөгийн элэгдэл бодогдсоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл нэмэгдсэн нь Татварын байгууллагад төлөх ХХОАТ 657.0 мянган төгрөгийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,722.2 мянган төгрөг болж 1,046.1 төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө 4,417.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,369.5 мянган төгрөгийн элэгдэл бодогдож, бараа материал 49.64 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 128,768.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 128,268.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 500.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 128,768.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын 128,768.2 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэл 124,839.8 мянган төгрөг буюу 96.94 хувьтай байгаа нь төсвийн төлөвлөлтийг сайн хийсэнтэй холбоотой шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Сайншанд сумын ИТХ-ын нэмэлт дансанд 2018 онд төвлөрүүлсэн 210.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-с 2018 оны ажил дүгнэж 200.0 мянган төгрөгийн урамшуулал, нийт 410.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс тоног төхөөрөмжийн зардалд 210.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 13,069.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 12,560.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 76.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 432.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага тогтоож, дотоод хяналтыг сайжруулах талаар 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 432.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 76.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 60.1 мянган төгрөгт албан шаардлага тогтоож хүргүүллээ.

Үүнд:

1. Илүү тооцож олгосон 76.8 мянган төгрөгийн цалин нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт *“Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт *“Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Цалинг 60.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож суутгасан нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт *“Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон.

3. Ажилтнаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй, санхүүгийн тайланд өглөг үүсгээгүй зөрчил нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт *“Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”*, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.4 дэх заалт *“Нийгмийн даатгалын шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гүйцэтгэнэ”*. гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон.

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эд хариуцагчийн тайлан, эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг үлдэгдэлтэй тулган баталгаажуулах, ИТХ-ын батлагдсан төсвийг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сайншанд сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал.

1.1. Илрүүлэлт: Аудитаар илэрч залруулагдсан алдааны 42 хувь нь эд хариуцагчийн тайлантай холбоотой гарсан.

1.2. Эрсдэл: Хөрөнгө, материалын өөрчлөлтийг буруу илэрхийлсэн.

1.3. Өгсөн зөвлөмж: НББ-д тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, тайлан мэдээг хуулийн хугацаанд нь гаргах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,358,424.00</u>	<u>3,308,826.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	3,148,424.00	3,308,826.00
354	Хангамжийн материал	3,148,424.00	3,308,826.00
35410	Бичиг хэргийн материал	472,498.00	245,900.00
35420	Аж ахуйн материал	2,675,926.00	3,062,926.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,022,035.43</u>	<u>8,070,389.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,022,035.43	8,070,389.92
392	Биет хөрөнгө	8,022,035.43	8,070,389.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,430,000.00	98,430,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,001,166.61	-97,483,166.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,083,011.00	10,500,911.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,246,514.42	-8,353,116.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,294,231.50	20,294,231.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,587,526.04	-18,590,691.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	4,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-777,777.77
39217	Ном	50,000.00	50,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,380,459.43</u>	<u>11,379,215.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>657,001.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	657,001.00
413	Өглөг	00.00	657,001.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,380,459.43</u>	<u>10,722,214.92</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,380,459.43	10,722,214.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,768,306.99	11,768,306.99
51101	Өмч: - төрийн	11,768,306.99	11,768,306.99
512	Хуримтлагдсан үр дүн	-476,146.36	-1,134,390.87
51210	Өмнөх үеийн үр дүн	-476,146.36	-476,146.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-658,244.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,298.80	88,298.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,380,459.43</u>	<u>11,379,215.92</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	89,864,500.00	128,968,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	89,864,500.00	128,968,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	210,000.00	200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,654,500.00	128,768,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,654,500.00	128,768,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	93,774,989.90	129,626,444.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,815,871.90	124,498,051.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,815,871.90	124,498,051.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,894,683.00	60,653,975.01
210101	Үндсэн цалин	49,894,683.00	60,653,975.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,779,870.00	7,396,126.51
210201	Тэтгэврийн даатгал	4,560,423.00	5,713,674.62
210202	Тэтгэмжийн даатгал	273,101.00	787,152.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	301,363.00	273,713.00
210204	Ажилгүйдлийн даатгал	141,058.00	56,506.00
210205	Эрүүл мэндийн даатгал	503,925.00	565,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,178,526.00	8,850,694.50
210401	Бичиг хэрэг	1,163,633.00	2,298,848.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	3,528,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,314.00	487,586.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	528,579.00	2,536,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,254,600.00	500,000.00
210604	Урсгал засвар	1,254,600.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	236,900.00	653,000.00
210702	Дотоод албан томилолт	236,900.00	653,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,286,128.00	41,274,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,082,028.00	41,052,790.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	106,920.00

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,185,164.90	5,169,545.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,308,000.00	800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,877,164.90	4,369,545.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,959,118.00	5,128,392.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,959,118.00	4,128,392.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,959,118.00	4,128,392.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-3,910,489.90</u>	<u>-658,244.51</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-3,910,489.90</u>	<u>-658,244.51</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>89,864,500.00</u>	<u>129,178,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	89,864,500.00	129,178,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,000.00	410,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	210,000.00	410,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,654,500.00	128,768,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,654,500.00	128,768,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>87,866,500.00</u>	<u>124,760,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,866,500.00	124,760,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,697,382.00	119,631,907.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,894,683.00	59,996,974.01
210101	Үндсэн цалин	49,894,683.00	59,996,974.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,768,647.00	7,396,126.51
210201	Тэтгэврийн даатгал	3,711,547.00	5,173,727.00
210202	Тэтгэмжийн даатгал	514,300.00	444,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	411,400.00	555,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	102,900.00	110,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,028,500.00	1,112,399.51
2104	Хангамж, бараа материалын зардал	4,427,024.00	5,284,386.50
210401	Бичиг хэрэг	1,315,031.00	1,097,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,999,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,314.00	487,586.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	625,679.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	502,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	502,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	236,900.00	653,000.00
210702	Дотоод албан томилолт	236,900.00	653,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,668,128.00	45,001,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,464,028.00	44,774,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	90,000.00

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	98,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	38,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,200,000.00	800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,200,000.00	800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,169,118.00	5,128,392.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,169,118.00	4,128,392.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,169,118.00	4,128,392.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,998,000.00</u>	<u>4,417,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,998,000.00	4,417,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,998,000.00	4,417,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,998,000.00	4,417,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,998,000.00	4,417,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,998,000.00</u>	<u>-4,417,900.00</u>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	190,285.25	2,821,071.08	14,779,663.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	101,986.45	101,986.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,768,306.99	190,285.25	2,923,057.53	14,881,649.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-101,986.45	00.00	-101,986.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	511,286.01	511,286.01
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	-476,146.36	11,380,459.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	-476,146.36	11,380,459.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-658,244.51	-658,244.51
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,768,306.99	88,298.80	-1,134,390.87	10,722,214.92

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,768,200.00	128,768,200.00	0.00	100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	128,768,200.00	128,768,200.00	0.00	100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,768,200.00	123,839,807.02	3,928,392.98	96.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,261,000.00	59,996,974.01	3,264,025.99	94.84
Үндсэн цалин	63,261,000.00	59,996,974.01	3,264,025.99	94.84
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,907,600.00	7,396,126.51	511,473.49	93.53
Тэтгэврийн даатгал	5,685,200.00	5,173,727.00	511,473.00	91.00
Тэтгэмжийн даатгал	444,000.00	444,000.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	555,600.00	555,600.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	110,400.00	110,400.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	1,112,400.00	1,112,399.51	0.49	100.00
Хангамж, бараа материалын зардал	5,350,000.00	5,284,386.50	65,613.50	98.77
Бичиг хэрэг	1,100,000.00	1,097,250.00	2,750.00	99.75
Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,999,550.00	450.00	99.99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00	487,586.50	62,413.50	88.65
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	700,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	694,600.00	653,000.00	41,600.00	94.01
Дотоод албан томилолт	694,600.00	653,000.00	41,600.00	94.01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,255,000.00	49,209,320.00	45,680.00	99.91
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,000,000.00	48,982,400.00	17,600.00	99.96
Даатгалын үйлчилгээ	90,000.00	90,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	98,000.00	27,000.00	78.40
Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	38,920.00	1,080.00	97.30

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	800000.00	800000.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	800,000.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00	1000000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	128,768,200.00	128,768,200.00	0.00	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,768,200.00	128,768,200.00	0.00	100.00
Орон нутгийн төсвөөс	128,768,200.00	128,768,200.00	0.00	100.00
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	05.00	05.00	0.00	100.00
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	410,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	410,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	210,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	210,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	210,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	200,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	200,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	410000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	410,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	410,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		